

“РЕМИКОН” ХК-НЫ 2015 ОНЫ ЭЭЛЖИТ
“ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ”-ЫН ПРОТОКОЛ

2015 оны 04дүгээр сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

Хурал эхэлсэн цаг минут: 11:00 цагт

Ц.Эрдэнэбаяр: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. “Ремикон” ХК-ийн 2015 оны ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурал эхлэхэд бэлэн боллоо. Миний бие Ц.Эрдэнэбаяр Хурал зохион байгуулах комиссын дарга болон хурлын даргыг хийх болно. Та бүхэн тараасан материал дээр байгаа хурлын дэгийг баримтлах талаар анхаарна уу. Мөн уг хурал нь тэмдэглэл хөтлөгдөх тул хувьцаа эзэмшигч нар асуулт асуух, саналаа хэлэхдээ заавал нэрээ хэлж байна. Ингээд ХЭХурал нээснийг мэдэгдье. Хурлын ирцийг тооллогын комиссын дарга Б. Алтанцэцэг мэдээлнэ.

Б. Алтанцэцэг: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Би хурлын тооллогын комиссын дарга Б. Алтанцэцэг байна. Та бүхэнд хурлын ирцыг танилцуулъя. Хуралд нийт 20 хувьцаа эзэмшигч ирсэн байна. Хувьцаа эзэмшигчдийн 63% хувьцааг эзэмшигчид хуралд ирсэн тул хурал эхлэхэд хүчин төгөлдөр боллоо гэдгийг хурлын даргад мэдэгдье.

Ц.Эрдэнэбаяр: Хурал дээр хэлэлцэх хэд хэдэн асуудал байна. Үүнд:

1.Ремикон ХК-ийн 2014 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцсэн Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах,

2.Ремикон ХК-ийн 2015 оны санхүүгийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулах,

3.Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7-д заасны дагуу Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, томилох,

4.Ремикон ХК-ийн 2014 оны санхүүгийн жилийн ашигаас Монгол улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6-д заасны дагуу ногдол ашиг хуваарилахгүй талаар танилцуулах,

5.Монгол улсын Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.4-т заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл үйл ажиллагаа санхүүгийнхаа тайланг танилцуулах,

6. “Ремикон” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах төсөв батлах

Хурлын бүрэлдэхүүнд Ремикон ХК-ийн Гүйцэтгэх захирал Г. Цогнэмэх, ТУЗ-ын нарийн бичгийн дарга Н. Энх-Очир, ТУЗ-ын дарга Х. Ганхуяг, Хурлын зохион байгуулах комиссын дарга Ц. Эрдэнэбаяр нар ажиллаж байна.

За ингээд 1-р болон 2-р асуудал буюу Ремикон ХК-ийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан төлөвлөгөөг танилцуулах, Ремикон ХК-ийн 2015 оны санхүүгийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулах асуудалдаа орье. Ингээд уг асуудлыг Гүйцэтгэх захирал Г.Цогнэмэх захирал танилцуулах болно.

Г.Цогнэмэх: Сайн байцгаана уу. "Ремикон" ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Цогнэмэх байна. 2014 оны ажлын болон санхүүгийн тайланг танилцуулах гэж товчхон танилцуулга бэлдсэн байгаа. Та бүхэнд тараасан хурлын тараах материалд хавсарган оруулсан байгаа ба асуух зүйл байвал танилцуулгын дараа лавлан асууна уу. Г. Цогнэмэх- Ремикон ХК-ийн 2014 оны Санхүүгийн тайланд ТУЗ-ын өгсөн дүгнэлтийг хэлэлцэх, батлах талаар танилцуулга тавив. Танилцуулгыг бүрэн эхээр нь хавсаргав.

Ц.Эрдэнэбаяр: За баярлалаа. Уг тавьсан тайлантай холбогдох асуулт байвал асууцгаана уу? Хувьцаа эзэмшигч та нэрээ хэлээд асуултаа асууж идэвхитэй оролцоорой.

Хувьцаа эзэмшигч Фронтер ХХК: Миний зүгээс танай компанид хэлэх санал байна. Одоогийн хийгдэж байгаа ажлуудыг дэмжиж байгаа ба нэмээд хятад улс монголын барилгын салбарт нилээд байр суурь эзэлж байна энэ жил нилээд олон барилга барих төлөвтэй байгаа гэсэн. Борлуулалтын ажилчдаа эдгээр хятадын компаниудтай холбож нэмж ажил олох арга бас байна. Мөн салбарын бүтэцэн өөрчлөлт явагдаж байгаа учраас аль өсөх боломжтой томоохон бетон зуурмагийн компаниудтай хамтран ажиллах байдлаар өөрсдийн боломжоо гаргаж ажиллавал зүгээр байна.

Хувьцаа эзэмшигч Энхтуяа: Танай компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн өнөөгийн нөхцөл байдлыг ерөнхийдөө ойлгож байна. 2014 оны санхүүгийн үйл ажиллагааны тайлан болон 2015 оны санхүүгийн төсөвтэй танилцлаа. Танай хамт олонд баяр хүргээд өөрийн зүгээс 2 санал хэлмээр байна. Жил бүрийн хувьцаа эзэмшигчдын хурлаас ажлын 5 тав хоногийн өмнө тухайн жилийн өөрсдийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан болон ирэх жилийн төсөвөө бидэнд брокер диллерийн байгууллагуудаар дамжуурлан өгч баймаар байна. Бидний хувьд танай тайланд эдийн засгийн хувьд дүгнэлт өгөхөд хугацаа тулсан хэцүү байна. 2-рт Хөндлөнгийн аудит гэж хөндлөнгийн зүгээс танай компанийн үйл ажиллагаа болон санхүүд өгч байгаа дүгнэлт учраас энэ асуудлын авч үзмээр байна. Бусад компаниудыг харахад хөндлөнгийн аудитаар дүгнэлт хийлгэсний дараа хувьцаа эзэмшигчдын хурлаа хийдэг. Танай компанийн удирдлагууд энэ асуудал дээр анхаарч ажилламаар байна. Мөн үйл ажиллагааны зардлаасаа гадна бусад зардалаа багасгаж

ажиллах хэрэгтэй байна. Мөн өнөөдрийн хурлаар танилцуулагдах ТУЗ-ын хараат болон хараат бус гишүүдийн танилцуулгыг харж байхад санхүү, эдийн засаг, бизнесийн чиглэлээр төгссөн олон талын улсууд байгаа учраас олон талын мэдлэгтэй эдгээр хүмүүс компаниа аваад явна гэдэгт итгэлтэй байна.

Г.Цогнэмэх: Танийг бидний нөхцөл байдлыг харгалзан үзэж ойлгож дэмжиж байгаад баярлаж байна. 2014 онд бид 1.3 тэр бум төгрөгийн алдагдалтай ажилласан ч энэ жил бид алдаан дээрээ суралцан ажиллая гэсэн төлөвлөгөөтэй байна. Аудитын хувьд бид Deloitte Онч аудит ХХК-аар аудит хийлгэхээр сонгосон байгаа ба өмнөх жилийн тайлангуудыг үзэж өөрсдөө шалгасны үндсэн дээр аудит хийгдэг учраас хугацааны хувьд өөрчлөлттэй байна. Гэсэн хэдий ч шахуу хуваарийн дагуу аудит хийж хугацаандаа дүгнэлтээ гаргаж ажиллах төлөвлөгөөтэй байна. Урьдчилсан байдлаар урьдчилсан дүгнэлтийг гаргуулж авсан ба энэ дүгнэлтээр ямар нэгэн асуудал байхгүй гэж дүгнэсэн байгаа. Хурлын тараах материалын хувьд хуульд заасан хугацаанд хүргүүлсэн байгаа ба хувьцаа эзэмшигчид маань бүртгэлтэй байгаа брокер диллерийн байгууллагуудаараа дамжуулан авах боломжтой. Нөгөө талаасаа бидэнд шууд хандан хэрэгтэй материалуудаа авч танилцах боломжтой байгаа. Бидэнтэй мөн байнгын холбоотой байж санал зөвлөгөөгөө өгч байвал хэрэгтэй байна.

Хувьцаа эзэмшигч Баатаржав: Миний хувьд та бүгдэд хандаж хэлэх санал байна. Бласт ХХК-аас авах авлагын хэмжээ нь 8,8 тэр бум боловч хөрөнгийн бирж дээрх үнэлэмж нь 6,6 тэр бум байна. Мөн 2 тэр бумын авлага байгаа нь бартерийн авлагын хэмжээ их байгаа гэж санагдаж байна. Борлуулалтын авлага гэж үзэж болох уу. Яг байраар авсан авлагууд ямар хэмжээтэй, найдваргүй авлага ямар хэмжээтэй байгаа вэ? Нийт хэдэн бартерийн байр байгаа вэ? Ер нь бол миний хэлэх гэж байгаа саналын хувьд авлага аль болох багасгаж, бартерийн байрны үнийг бууруулж зарж борлуулах хэрэгтэй байх гэж үзэж байна.

Г. Цогнэмэх: Манай компани ер нь бол бартераар борлуулалт хийхийг илүүд үзэхгүй байгаа. 2014 оны хувьд нэг л компанитай бартерийн гэрээ хийсэн нь Номин констракшн ХХК байсан бөгөөд нийт 15.000 м3 орчим бетон зуурмагийн ажилд бартер хийсэн багйгаа. Ер нь бол нийт гэрээний 20%-аас илүү хувьд бартерийн гэрээ хийхгүй гэсэн бодлоготой байгаа. Харин бартераар авсан байраа бол бид нийлүүлэгч нартаа эргүүлэн бартер хийж одоо бол цөөхөн байр үлдсэн байгаа.

Хувьцаа эзэмшигч Фронтер ХХК: Надад асуух хэд хэдэн асуулт байна. Нэгдүгээрт санхүүгийн тайланд харагдаж байгаа том том өрүүдийн задаргаа хэрэгтэй байна. Мөн санхүүгийн тайлан бусад мэдээллээ веб сайтан дээрээ байнга байршуулж байх шаардлагатай байна. Тэгвэл шууд үзэх боломжтой амар байна. Та нарын хувьд брокер деллерийн байгууллагуудаар дамжуулан мэдээллээ хувьцаа эзэмшигчдэд хүргэдэг гэсэн боловч танай компанийн зүгээс илүү их оролцох хэрэгтэй байна. Хоёрдугаарт олон ТУЗ-ын

гишүүн байх шаардлага байна уу? Гуравдугаарт хөндлөнгийн аудит хийлгэхээр сонгосон Deloitte аудитын хувьд дэмжиж байна. Учир нь олон улсын аудитад итгэх итгэл үнэмшил их байдгын хувьд энэ аудитын компаниар хийлгэхийг дэмжиж байна. Дөрөвдүгээрт авлагын дүн 7 тэр бут төгрөг байгаа нь маш их хэмжээ байна. Ихэнх авлага нь орон сууцаар байгаа гэж танилцуулсан. Орон сууц бол мөнгө биш учраас эдийн засгийн нөхцөр байдлаас хамаарч үнэ нь 50% орчимоор унах магадлалтай байдаг. Тэр тохиолдолд авлага өөрөө найдваргүй зээл болох магадлалтай өндөртэй байна. Үүнийг яаж шийдэх бодолтой байна.

Г.Цогнэмэх: Нэгдүгээр асуултын хувьд санал нэг байна. Тийм болохоор аль болох компанийн зүгээс идэвхитэй ажиллая гэж бодож байна. Хоёрдугаар асуудлын хувьд ТУЗ-ын гишүүдийн тоо нь хурал зөвөлгөөн хийхэд ирц бүрдүүлэх гэдэг утгаараа хүндрэлтэй байж болох ч энэ жилээс бид ТУЗ-ын ажиллагааг онлайн аар санал асуулгаа аваад явуулдаг болоод байна. Нөгөө талаасаа олон ТУЗ-ын гишүүнтэй байна гэдэг нь бидэнд зардалаа багасгах санаатай байгаа. Хараат бус гишүүдийн цалинг тухайн сард ТУЗ-ын хурал хийж байгаа тохиолдолд цалин олгож хурал хийгээгүй сард цалин олгохгүй байхаар шийдсэн байгаа. Харин хараат гишүүд маань ерөөсөө цалингүйгээр ажиллах болсон байгаа. Тэр утгаараа ТУЗ-ын зардал нилээд буурсан байгаа. ТУЗ-ын нарийн бичгийн дарга болон ТУЗ-ын дарга нар л цалингаа тогтмол авахаар төсөвлөсөн байгаа. Гуравдугаарт аудитын хувьд дэмжиж ойлгож байгаад баяртай байна. Дөрөвдүгээрт авлага үнэхээрийн хнд байгаа. Та бүгдэд өгсөн материалаас харсан байх. Бид авлагаа нийлээн барагдуулж хичээж ажиллаж байгаа гэсэн хэдий ч 3 том авлага байгаа. Мэргэн девелипмент ХХК, Бүти ХХК, Архангайн ТОСК-ийн санхүүжилтээр хийгдэж байгаа барилгын авлага байгаа. Эдгээр авлагуудаа бид баталгаажуулаад барьцааны гэрээ хийсэн байгаа. Гэсэн ч авлага орж ирэхгүй байгаа нь компанид сөргөөр нөлөөлж байна. Бусад авлагын хувьд баталгаажуулсан бага багаар барагдуулж байгаа. Нийтдээ 10 гаран компанийг шүүхэд өгч шүүхийн шийдвэр гүйцэтгэлээр дамжин авлага барагдуулалт хийгдэж байгаа. Орон сууцны хувьд бид эрсдэлээ бодоод авлагандаа авахгүй эрсдэлтэй байгаа учраас байр авах эзэнийг нь олсон үедээ бид байрыг бартераар авч бартераар авсан үнээр нь буцаан зарж борлуулж байгаа. Бусад үед барьцаанд хураагдау орж ирсэн байр бол орж ирж байгаа. Гэхдээ бартераар авахдаа үнийг бууруулж, хугацаа удаасан авлагандаа алданги тооцож явж байгаа.

Хувьцаа эзэмшигч: Элэгдэлийн зардалын дүн өндөр байна. Энэ дүнг буруулах арга хэмжээ юу байна. Мөн үйл ажиллагааны зардлыг бууруулах арга юу байна.

Г.Цогнэмэх: Элэгдэлийн зардалд бодитой байгаа зүйл бол 2 үйлдвэр, 60 гаруй техник байна. Өөр элэгдэл тооцогдох том хэмжээний өртөгтэй зүйл байхгүй байгаа. Нийт элэгдэлийн зардал 1.100 сая төгрөгийн элэгдэлийн зардал байгаа. Тийм учраас энэ элэгдэлийн зардал нь яг бодитой дүн байгаа. Дүн буулгах нэг арга нь тоног төхөөрөмжөө

зарж борлуулах арга байна. Өнөөдрийн байдлаар тоног төхөөрөмжөө зарж борлуулах гэсэн боловч зах зээлийн ханш нь унасан авсан үнэдээ хүрэхгүй байх аюултай болоод байна. Үйл ажиллагааны зардалын хувьд бид боломжтой бүх зардалаа байхгүй болгосон. Бид нийтдээ өнгөрсөн 2013 онд цалингийн зардал 823 сая төгрөг байсан боловч бид энэ жил цалингийн зардалаа 500 сая төгрөгөнд багтаахаар төсөвлөсөн байгаа. Эндээс 300 сая төгрөгийн хэмнэлт хийсэн байгаа. Түлшний зардал болон тээврийн хэрэгсэлийн зардал өөрөө хувьсах зардалд ордог байгаа энэ зэрдэл маань 2012 онд 1.400 сая төгрөг, 2013 оны 900 сая төгрөг, 2014 онд 700 сая төгрөг байснаас бид 2015 онд 400 сая төгрөг болтол бууруулахаар төсөвлөсөн байгаа. Мөн дээрээс нь хэмжиж байгаа нэг зардал нь элэгдэлийн зардалаас 1 помпоо зарах болон бусад зарах боломжтой техникийн жагсаалтаа гаргах зарахаар ажиллаж байна.

Ц. Эрдэнэбаяр: Өөр асууж тодруулах зүйлгүй бол 15 минутын хугацаанд завсарлаад эргээд хуралдах саналтай.

Хурлын завсарлага 15 минут үргэлжлэв.

Ц.Эрдэнэбаяр: За хуралдаа эргээд орье. Асуух зүйлсээ тэмдэглэж авч байгаарай. Эхний хэлэлцэх асуудал дээр танилцуулга явагдлаа. Одоо ТУЗ-ийн гишүүдийг сонгохтой холбогдуулан танилцуулгыг ТУЗ-ийн нарийн бичиг Н. Энх-Очир та бүхэнд танилцуулна.

Н. Энх-Очир: Сайн байцаана уу. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Энх-Очир байна.

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7-д заасны дагуу Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, томилох асуудлаар ТУЗ-ын дэргэдэх нэр дэвшүүлэх хороо хуралдаж хэд хэдэн нэр дэвшигчдээс сонголт хийж ТУЗ-ын хуралд танилцуулсан байгаа. Нэр дэвшүүлэх хороо 2015 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр хуралдаж дараах шийдвэрийг гаргасан байгаа. Ремикон ХК-ийн хараат бус гишүүний жагсаалтыг хавсралт 1-ээр баталж, хараат гишүүдийг хавсралт 2-оор баталж дүгнэлтийг ТУЗ-ын хуралд танилцуулан ХЭХ-аар шийдвэрлүүлэх шийдвэр гаргасан байна. Энэ дүгнэлт шийдвэр гарсаны дагуу 2015 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр ТУЗ-ын хурал хуралдаж дараах тогтоолыг гаргасан./танилцуулах материалд тогтоол болон ТУЗ-ын хараат болон хараат бус гишүүдийн танилцуулгыг бүрэн эхээр нь хавсаргав/. Нэр дэвшүүлэх хорооны шийдвэрийн дагуу ТУЗ-ын хараат бус гишүүнээр дараах 4 хүн нэр дэвшсэн байгаа. 2014 онд хараат бус гишүүнээр ажиллаж байсан Золбоо, Батгэрэл, Алтанхуяг гэх гишүүдийг улируулан сонгохоор шийдвэрлэж, харин Дашдондог гишүүний оронд Баянмөнх хэмээх хүнийг шинээр нэр дэвшүүлсэн байгаа. Баянмөнх гишүүн шинээр сонгогдож орж ирсэн гишүүний хувьд өөрийгөө танилцуулах байгаа. ТУЗ-ын хараат гишүүдийн хувьд Х. Ганхуяг, Мандар, Мөнгөнсүх,

Эрдэнэбаяр гишүүдийг улируулан сунгах харин шинээр нэр дэвшүүлэх хорооноос Э.Мөнхсайхан, Игата Масатэру, Г.Цогнэмэх нарыг дэвшүүлсэн байгаа. Шинээр хараат бус гишүүнээр нэр дэвшигч С. Баянмөнхийн танилцуулгыг сонсое.

С. Баянмөнх: Юуны өмнө эрхэм хувьцаа эзэмшигчид болоод ТУЗ-ын гишүүд, энд хүрэлцэн ирсэн нийт хүмүүстээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Намайг С. Баянмөнх гэдэг. Тараах материал дээрээс миний талаар товч танилцуулгыг харах боломжтой. Яагаад би ремикон ХК-ийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтанд орох болсон тэ? Гэвэл зарыг олон нийтийн сувгаар дамжуулан харж, үүний дагуу шаардлагатай материалыг бүрдүүлж холеогдох хаягаар хүргүүлсэн. Үүнээс хойш удаа дараагын уулзалт ТУЗ-ын хурал гэсэн шат дамжлагатайгаар явж өнөөдрийн хурал дээр ирээд байна. Талархалтай байна. Нэгдүгээрт ашиг сонирхлын хувьд Ремикон ХК-ын ТУЗ-ын аль нэг гишүүд болоод компанийн ажилчидтай гэр бүлийн болон садан төрлийн харьцаагүй зөрчилгүй билээ. Хоёрдугаарт өөр нэг байгууллагад давхар ТУЗ-ын гишүүний ажлыг давхдуулах хийдэггүй. Ёс зүйн чиглэлийн хувьд миний ойлгож байгаар миний үүрэг бол Хувьцаа эзэмшигчдын эрхийг хамгаалж, түүн дотроо жижиг хувьцаа эзэмшигчдын эрх ашгийг илүү их онцгойлон анхаарах ТУЗ-ын хурлаар яригдаж байгаа мэдээ, мэдээллүүд, асуудлуудыг компанийн үйл ажиллагаа, түүний дотор гүйцэтгэх захиралын удирдлагын багын үйл ажиллагааны талаар бодит мэдээллийг Хувьцаа эзэмшигчдэд үнэн бодитоор хүргэх хүрээнд ажиллана. Би өөрөө BP MONGOLIA GROUP-ын Гүйцэтгэх захирал хийдэг. Манай компани нь хөрөнгө оруулалтын чиглэлээр ажилладаг, энэ дотроо барилгын салбарын чиглэлээр илүү ихээр ажилладаг. Барилгын салбарын хувьд ажил хэргийн болон хувийн шугамаар тодорхой хэмжээгээр гадарлана. Мэдээж барилгын салбар уналттай байгаа хэдий боловч манай Ремикон ХК-нд миний ажиглалтаар бол энэ хүнд үед маш чадварлаг менежментийн баг, маш чадварлаг менежментийн үйл ажиллагааг нэтрүүлсэнээр энэ хүнд үеийг маш ухаалаг байдлаар даван туулах боломжтой. Өнөөдөр хэцүү байгаа манай компанийн алсыг харж байгаа ирээдүйтэй гэж бодож байгаагын хувьд энэ багт өөрөө ороод ТУЗ-ын багт ороод хүнд хэцүү нөхцөл байдлыг амжилттай бизнесийн хөгжлийн хувьд дараагийн шатанд нь гарахад хувь нэмрээ оруулах хүсэл зорилгыг агуулсан юм. Мэдээж барилгын салбар хүнд байна. Энэ салбарыг хөгжүүлэхын тулд төр эдийн үасгаас янз бүрийн арга хэмжээ явуулж байна. Гол хүндрэл нь барьсан барилгаа борлуулах асуудал байна. Учир нь түвшин түвшинд яригдаж байгаа бартерийн асуудлуудыг төрөөс дэмжиж ажиллахаар хичээж байна. Бид хамгийн гол нь ухаалаг байдлаар бизнесээ доройтуулахгүйгээр амьд үлдэж чадвал эдийн засаг аяандаа сайжирна. Олон олон зээл төслүүд хэрэгжинэ. Эдгээр төслүүдийг бид хүлээх биш зах зээлрүү довтолсон байдлаар бид ажиллах хэрэгтэй байна. Намайг дэмжиж ажиллана гэдэгт итгэж найдаж байна.

Ц.Эрдэнэбаяр: За баярлалаа. ТУЗ-ын хараат бус гишүүнээр шинээр нэр дэвшсэн С. Баянмөнх гишүүний танилцуулга сайхан боллоо. ТУЗ-ийн гишүүдийн дэлгэрэнгүй материалыг тараасан материалд дэлгэрэнгүй бичсэн байна. Одоо 4-р асуудал болох Ремикон ХК-ийн 2014 оны санхүүгийн жилийн ашигаас Монгол улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6-д заасны дагуу ногдол ашиг хуваарилахгүй талаар танилцуулах мэдээллийг ТУЗ-ын нарийн бичгийн дарга Н. Энх-Очир өгнө.

Н. Энх-Очир: ТУЗ-ийн 2015 оны 3-р сарын 09-ны өдрийн ТУЗ-н хурлаар Гүйцэтгэх удирдлагын хүсэлтийг харгалзан үзээд дараах шийдвэрийг гаргасан байгаа. Шийдвэрийг үрэн эхээр танилцуулах материалд хавсаргав. Уг шийдвэртэй холбоотойгоор хувьцаа эзэмшигчдээс асуух асуулт байна уу?

Ц.Эрдэнэбаяр: Уг шийдвэртэй холбоотойгоор хувьцаа эзэмшигчдээс асуух асуулт байхгүй бол 5-р асуудал болох Монгол улсын Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.4-т заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл үйл ажиллагаа санхүүгийнхаа тайланг танилцуулахыг ТУЗ-ын нарийн бичгийн дарга Н. Энх-Очир танилцуулна.

Н. Энх-Очир: Товчхондоо 2014 оны 04 дүгээр сараас 2015 оны 04 дүгээр сар хүртэлх тайланг гаргасан байна. Ремикон ХК нь энэ хугацаанд ТУЗ-ын хараат 7, хараат бус 4 гишүүн нийт 11 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр нийт 4 удаагийн хурал зохион байгуулсан байгаа. Төлөөлөн удирдах зөвлөл үйл ажиллагаа санхүүгийнхаа тайланг хурлын материалд бүрэн эхээр нь хавсаргав.

Ц.Эрдэнэбаяр: За тэгэхээр ТУЗ-ийн тайлан болон санхүүгийн тайланг нь танилцууллаа. Энэ хэлэлцэж буй асуудалтай холбогдох асуулт байвал асууж болно.

Хувьцаа эзэмшигч Төмөрбаатар: Танай компани өөр компанийн ТУЗ-ын гишүүдийн цалин хөлсийг судалсан зүйл байна уу?

Н. Энх-Очир: Ер нь холбогдох журмынхаа дагуу ТУЗ-ын гишүүдийн цалингын хэмжээг тогтоох шийдвэрийг ТУЗ-ын цалин урамшуулалын хороо шийдвэрээ гаргадаг байгаа. Цалин урамшуулалын хороо уг шийдвэрийг гаргахын тулд анх цалингийн үнэлгээ тогтоож байхдаа судалгаа хийж байсан байгаа. Тэр судалгааны үндсэн дээр энэ цалин хөлсний үнэлгээ гарч ирсэн байгаа.

Хувьцаа эзэмшигч Төмөрбаатар: Цалин давхардаж олгогдох асуудал гарах уу?

Г. Цогнэмэх: Ер нь цалин огт давхардаж олгогдохгүй байгаа. Бүр ТУЗ-ын хараат гишүүд огт цалин авахгүй байхаар энэ жилээс төсөвлөгдөж энэ жил нийтдээ 6 хүн цалин авахаар байгаа бөгөөд хараат бус гишүүд тухайн ТУЗ хуралдсан сард л цалин бодогдохоор шийдвэрлэсэн нь цалингийн зардалаа хэмнэсэн явдал болж байгаа юм.

Хувьцаа эзэмшигч Төмөрбаатар: Одоо тэгвэл энэ хараат гишүүдийн цалин болох 250.000 төгрөг олгогдохгүй болсон гэсэн үг үү?

Г.Цогнэмэх: Тийм ээ.2015 оны оны төсөвт тэгэж заасан байгаа.

Хувьцаа эзэмшигч Төмөрбаатар: хараат болон хараат бус гишүүдийн 2 ялгавартай цалин байна.

Ц. Эрдэнэбаяр: За би энэ асуултанд харилт өгье. Та 2014 оны тайлан болон 2015 оны төсөв хольж ойлгоод байх шиг байна. 2 өөр асуудал байна. Ер нь бол ТУЗ-ын хараат болон хараат бус гишүүдийн хувьд цалингийн судалгааг хийсний үндсэн дээр дээрх цалигийн үнэлгээг гаргасан ба энэ үнэлгээ нь бусад компаниудын цалингийн үнэдгээнээс бага байгаа гэж ойлгож болно.

Ц.Эрдэнэбаяр: 5-р асуудлын хувьд асуух асуулт байхгүй бол 6-р асуудал болох "Ремикон" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах төсөв батлах танилцуулгыг Н. Энх-Очир танилцуулна.

Н. Энх-Очир: "Ремикон" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах төсөв батлах тухай танилцуулгыг хурлын материалд бүрэн эхээр нь хавсаргав.

Ц.Эрдэнэбаяр: "Ремикон" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах төсөв батлах асуудалаар асуух асуулт байна уу? Асуулт байхгүй бол нийт хэлэлцсэн 3 асуудал дээр санал авахтай холбоотойгоор Тооллогын комиссоос мэдээлэл өгнө. Үүний дараагаар Зохион байгуулах комиссоос өдрийн хоолыг бэлдсэн байгаа. Та бүхэнд үүнтэй холбоотой мэдээлэл хийе. Анхааралтай сонсоорой. Сайн асууж аваарай.

Тооллогын комиссын дарга Б. Алтанцэцэг: Энгийн хувьцаа тус бүр сонгогдох гишүүдийн тоотой тэнцэх саналын эрхтэй байх бөгөөд хувь нийлүүлэгч нь өөрийн хувьцаанд ногдох саналаа бүгдийг нь нэг хүнд, эсвэл хэд хэдэн хүнд хуваан өгөх эрхтэй. Нэр дэвшигч бүрд өгсөн саналын тооны нийлбэр нь тухайн хувьцаа эзэмшигчийн саналын эрхийн тооны нийт дүнгээс илүүгүй байх бөгөөд саналын эрхийн тооны нийт дүн нь тухайн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. Гол нь нэр дэвшигч бүрт өгсөн саналын тооны нийлбэр нь таны

санал өгөх эрхийн нийт тооноос илүү байж болохгүй. Хэрэв илүү гарсан тохиолдолд таны саналын хуудас хүчингүй болно гэдгийг анхаарна уу.

Ж/нь: Та 100 ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг гэвэл таны санал өгөх эрхийн тоо ТУЗ-д $11 \cdot 100 = 1100$ ширхэг байна. Түдгэлзэж болно. Яаж өгөх нь та нарын эрхийн асуудал юм.

Ц.Эрдэнэбаяр: Та бүхэнд бүртгэлийн хуудас өгсөн байгаа. Таны эзэмшиж буй хувьцааны тоог тавьж өгсөн байгаа. Үүнтэй холбогдуулан энэ миний хувьцааны тоо мөн гэж үзэж байвал энэ хувьцааны дүнгээ хүмүүс дээрээ өөрийн саналаа тавиарай. Нэг хүн дээр ч тавьж болно.

Б. Алтанцэцэг: За 2 дахь асуудал бол энэ хуралд орж байгаа зөвшөөрсөн татгалзсан түдгэлзсэн гэдэг бол нэг л саналын эрхтэй гэсэн үг. Зөвлөөл болох юм.

Ц.Эрдэнэбаяр: За саналын хуудсыг ойлголоо бөглөхөд бэлэн боллоо гэж үзэж болох уу. За тэгэхээр та бүхэн саналаа өгөөд санал тоолох комисст шилжүүлнэ.

Хурлын завсарлага 20 минут үргэлжлэв.

Тооллогын комиссын дарга Б. Алтанцэцэг: ХЭХ-д нийт 20 хувьцаа эзэмшигч буюу 49,460,504 ширхэг хувьцааг эзэмшигчид байж энэ нь нийт хувьцаа эзэмшигчдийн 63% болж, хурлын ирц бүрдсэн байна. ХЭХурлаар хэлэлцсэн асуудлын хүрээнд санал хураалт явуулахад нийт 20 хүний бүрэлдэхүүнтэй байснаас 20 саналыг хүчинтэйд тооцсон болно. Санал хураалтын үр дүнд: Ремикон ХК-ийн 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал авсан.

Нэгдүгээр асуудал: Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь сунгах асуудалд Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат гишүүнд нэр дэвшигч нар Х.Ганхуяг - 103,6%, Ж.Мандар – 98,4%, И.Масатэргү – 99,6%, Ч.Мөнгөнсүх – 99,6%, Ц.Эрдэнэбаяр – 99,6%, Э.Мөнхсайхан – 99,6%, Г.Цогнэмэх – 101,8%, хараат бус гишүүнд нэр дэвшигч нар Н.Золбоо – 99,6%, Н.Батгэрэл – 99,6%, Д.Алтанхуяг – 99,6%, С.Баянмөнх – 99,6% хувийн зөвшөөрсөн санал авч ТУЗ-ийн гишүүдээр дахин сонгогдсон байна.

Хоёрдахь асуудал: Ремикон ХК-ийн 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал авсан 2-р асуудал болох Ремикон ХК-ийн 2013 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн дүгнэлтийг батлах тухай асуудал санал хураалтаар 99,6% хувийн зөвшөөрсөн санал авсан.

Гуравдахь асуудал: Ремикон ХК-ийн 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал авсан 3-р асуудал болох ТУЗ-ийн ажиллах төсөв батлах асуудалд Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, хараат гишүүн, хараат бус гишүүн, нарийн бичгийн дарга нарын цалингийн дээд хязгаар, олгох нөхцөл зэргийг

хэлэлцсэн Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 04 дугаар сарын 20-ний өдрийн дугаар 15/2/3 тоот шийдвэрийг батлах тухай асуудал санал хураалтаар 99,6% хувийн зөвшөөрсөн санал авсан байна.

Ц.Эрдэнэбаяр: Ингээд санал хураалтын дүнгээс үндэслэн гарсан ХЭХ-ын тогтоолуудыг уншиж танилцуулъя. Уншиж танилцуулав. ТУЗ-ийн шинээр томилогдсон гишүүддээ болон дахин сонгогдсон гишүүддээ баяр хүргэж ажлын амжилт хүсье. Хурал дэгийн дагуу амжилттай явагдаж дууслаа. Та бүхэнд хурал хаасныг мэдэгдье.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ЭРДЭНЭБАЯР

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН



Н.ЭНХ-ОЧИР